



ДУНДГОВЬ АЙМАГ  
ЭРДЭНЭДАЛАЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 02 сарын 16 өдөр

Дугаар 1/31

Сангийндалай

80-89 настай ахмадуудад хүндэтгэл  
үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.5 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дүгээр тушаалаар баталсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.4, 2.1.5 дахь заалт, сумын Засаг даргын Зөвлөлийн 2023 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн 02 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монголын цагаан сарын баярыг тохиолдуулан сумын 80-89 настай 66 ахмадуудад хүндэтгэл үзүүлсүгэй.
2. Ахмадын нэрс, зардлыг хавсралтаар баталсугай.
3. Ахмадуудад хүндэтгэл үзүүлэхэд шаардлагатай 1,650,000 (нэг сая зургаан зуун тавин мянган) төгрөгийг Засаг даргын Тамгын газрын Орон нутгийн нөөц хөрөнгийн зардлаас санхүүжүүлэхийг Засаг даргын Тамгын газрын дарга (Г.Энхдэлгэр), нягтлан бодогч (Ж.Хишигсүрэн) зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГЫН  
ОРЛОГЧ О.БАЗАРРАГЧАА



482302006